

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ГАРАХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

2024 оны 04 дүгээр сарын 08

Улаанбаатар хот

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Түвшин /тоо хэмжээ									Нийт	Тайлбар
			2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023		
1	Биеийн тамир, спортын хамтлаг	Хамтлагийн тоо өсөлт	702	720	730	785	795	795	797	805	808	808	Нийслэлийн Засаг даргын 2006 оны А/164 дүгээр захирамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд 808 биеийн тамир, спортын хамтлаг байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.
2	Магадлан итгэмжлэлд хамрагдсан байгууллага	Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб /өссөн дүнгээр/	0	0	0	0	11	11	13	13	13	13	Спорт клубүүд магадлан итгэмжлэлд сайн дурын үндсэн дээр хамрагдах, магадлан итгэмжлэгдсэн клубүүдэд хичээллэж буй иргэд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал авах эрх зүйн орчин 2019 оноос үйлчилж 2021 оноос түр зогссон бөгөөд нийслэлийн хэмжээнд 13 спорт клуб магадлан итгэмжлэлд хамрагдсан байна.
3	Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагаанд оролцсон иргэд	Биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчдын тоо /өссөн дүнгээр/	607,142	673,540	709,961	760,835	756,451	58,310	635,486	1,170,073	873,313	6,245,111	2015-2023 оны хооронд зохион байгуулсан нийтийн биеийн тамирын томоохон арга хэмжээнд давхардсан тоогоор 6,245,111 иргэн хамрагдсан байна.
4	Өвлийн арга хэмжээнд оролцогчдын тоо	Арга хэмжээнд оролцогчдын тоо /өссөн дүнгээр/	4500	4906	10,000	418,713	400,000	0	287,800	416,572	425,100	1,967,591	2021 онд "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 дугаар захирамжаар үйл ажиллагааг нь хязгаарлах салбар, чиглэлд биеийн тамир, спортын арга хэмжээ орсонтой холбогдуулан "Мөнгөн Улаанбаатар" өвлийн наадмыг зохион байгуулах боломжгүй болсон. 2015-2023 онд өвлийн биеийн тамир, спортын арга хэмжээнд давхардсан тоогоор 1,967,591 иргэн хамрагдсан.
5	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн тоо	Сорилд хамрагдсан иргэдийн тоо	196,658	132,081	150,503	162,129	165,100	0	0	175,417	175,000	976,888	2020, 2021 онд "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 дугаар захирамжаар үйл ажиллагааг нь хязгаарлах салбар, чиглэлд биеийн тамир, спортын арга хэмжээ орсонтой холбогдуулан хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах арга хэмжээг зохион байгуулаагүй. 2015-2023 онд бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд давхардсан тоогоор 976,888 иргэн хамрагдсан байна.
6	Багийн спортын төрлөөр зохион байгуулсан уралдаан тэмцээнд оролцсон хүүхэд, багачуудын тоо	Тэмцээн, уралдаанд оролцогчдын тоо /өссөн дүнгээр/	120,543	137,887	146,233	145,000	145,800	147,872	0	145,200	145,350	1,133,885	МУ-н шадар сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 128, А/433, А/754, А/196 дугаар хамтарсан тушаалаар нийслэлд байршилтай өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн танхимын сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс зайн сургалтад шилжүүлсэнтэй холбогдуулан "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейбол, хөлбөмбөгийн тэмцээнүүдийг зохион байгуулах боломжгүй болсон. 2015-2023 онуудад багийн спортын төрлөөр зохион байгуулсан тэмцээнд давхардсан тоогоор 1,133,885 хүүхэд, багачууд хамрагдсан байна.
7	Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын тоо	Тэмцээнд оролцогч тамирчдын тоо	4162	3170	4,416	150,358	152,096	3496	2839	7888	7967	336,392	2015-2023 онуудад Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын тоо
8	Спортын уралдаан тэмцээнд тамирчдын тоо	Тамирчдын тоо /өссөн дүнгээр/	46,321	32,550	62,800	204,224	198,566	153,803	7,086	155,138	190,158	1,050,646	2015-2023 онд зохион байгуулсан спортын уралдаан, тэмцээнд оролцсон тамирчдын тоо
9	Хамтарч ажилласан спортын холбоод	Тоо /нэмэгдсэн дүнгээр/	24	17	26	27	27	16	21	15	24	197	2015-2023 онд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор давхардсан тоогоор хамтран ажилласан спортын холбоод
10	Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн спортын төрлийн тоо	Өсвөрийн шигшээ багуудын спортын төрлийг нэмэгдүүлсэн тоо /өссөн дүнгээр/	19	19	22	23	22	22	24	24	28	28	Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 28 төрөлд хүүхэд, багачуудыг хамруулж байна.
11	Биеийн тамир, спортын зориулалтаар байгуулагдсан талбай	Тоо /нэмэгдсэн дүнгээр/	85	88	90	94	99	100	103	105	141	141	Биеийн тамир, спортын зориулалтын гадна талбай 141 байгуулагдсан байна.
12	Спортын барилга байгууламжийн хүртээмж	1000 хүнд ноогдох шалны талбай /мкв/	54	56	57	58	59	60	61	62	63.5	63.5	Спортын барилга байгууламжийн хүртээмж 63.5 мкв хүрсэн байна.